



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (315)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Улсын цол олгож, хөдөлмөрийн баатар, гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай.*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай*
- *Сургалтын төлбөрийн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны наймдугаар сарын 13

№ 30 (315)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

460.	Үндэсний сурын харваачдад цол олгох тухай	Дугаар 129	753
461.	Улсын начин цол олгох тухай	Дугаар 130	754
462.	Улсын харцага цол олгох тухай	Дугаар 131	754
463.	Улсын гарьд цол олгох тухай	Дугаар 132	754
464.	Улсын аварга цол олгох тухай	Дугаар 133	754
465.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай	Дугаар 134	755
466.	Гэлэгбалбарын Шаалайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 135	755
467.	Архангай аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 136	755
468.	Адъяагийн Рэнчинд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 137	757
469.	Лувсангэндэнгийн Аюушт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 138	757
470.	Лавагийн Юрад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 139	758

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

471.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 132	758
472.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 135	758
473.	Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай	Дугаар 136	760
474.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 137	760
475.	Сургалтын төлбөрийн тухай	Дугаар 139	760
476.	Журам батлах тухай	Дугаар 140	761
477.	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай	Дугаар 141	762

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Үндэсний сурын харваачдад цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

аймгийн харьяат, "Монросцветмет" нэгдлийн "Уурхайчин" клубын харваач Жанчивын Баттөмөр, эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Дорнод аймгийн харьяат, Багануур дүүргийн харваач Батын Бутваан нарт улсын мэргэн цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын үндэсний сурын эрэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Өмнөговь

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Улсын начин цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

- | | |
|--------------------------|---|
| Амгаланбаатар | сумын харъяат, "Бишрэлт" холдинг компанийн бөх |
| 4. Бавуудоржийн Баянмөнх | -Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын харъяат, "Хилчин" дэвжээний бөх |
| 5. Гунаажавын Эрхэмбаяр | -Сэлэнгэ аймгийн Мандал сумын харъяат, "Ноёд" группийн бөх |
| 6. Дугардоржийн Батбаяр | -Говь-Алтай аймгийн Бугат сумын харъяат, "Автобус-1" компанийн бөх |
| 7. Жүгдэрийн Гансүх | -Дорнод аймгийн Халхгол сумын харъяат, "Аварга" дээд сургуулийн бөх |

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 5 давсан дараахь бөхчүүдэд улсын начин цол олгосугай.

- | | |
|---------------------------|---|
| 1. Гарваагийн Олзгэрэл | -Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын харъяат, "Бишрэлт" холдинг компанийн бөх |
| 2. Сүрэнжавын Даваасамбуу | -Увс аймгийн Сагил сумын харъяат, "Алдар" ХК-ийн бөх |
| 3. Дорлигжавын | -Төв аймгийн Аргалант |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Улсын харцага цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

- | | |
|-------------------------|---|
| 1. Махгалын Баяржөвхлэн | -Завхан аймгийн Нөмрөг сумын харъяат, "Анод" банк, "Аварга" дээд сургуулийн бөх |
| 2. Эрдэнийн Батбаатар | -Увс аймгийн Тэс сумын харъяат, "Монгол газар" компанийн бөх |

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 6 давсан дараахь бөхчүүдэд улсын харцага цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Улсын гарьд цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

барилдаанд 8 давсан Өвөрхангай аймгийн Хужирт сумын харъяат, "Эрэл" компанийн бөх Долгорсүрэнгийн Сумъяабазарт улсын гарьд цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын хүчит бөхийн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Улсын аварга цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

барилдаанд 9 давж түрүүлсэн Архангай аймгийн Батцэнгэл сумын харъяат, "Бридж" группийн бөх Гэлэгжамцын Өсөхбаярт улсын аварга цол олгосугай.

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын хүчит бөхийн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон Бударгацаагийн Сарантуяаг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн заалт, шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн Ишийн Боролзойг Хэнтий аймаг дахь

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Гэлэгбалбарын Шаалайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж ерөнхий боловсролын сургуулиудыг мэргэжлийн удирдлагаар хангах, багш нарын заах аргыг дээшлүүлэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Архангай

аймгийн Боловсрол, соёл, төвийн арга зүйч Гэлэгбалбарын Шаалайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Архангай аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Архангай аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | | | |
|----------------------|--|-------------------------|--|
| 1. Бүд-Очирын Бядран | -Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан | 3. Сэндэнгийн Сүхбаатар | "Төгсхөнд" хоршооны захирал
-Архангай аймгийн Стандартчлал, хэмжилзүйн төвийн дарга |
| 2. Ендонгийн Давзаям | -Архангай аймгийн Эрдэнэмандал сумын | | |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | | | |
|-----------------------------|--|-------------------------------|--|
| 1. Цэрэндоржийн Бурхиа | -Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш | 6. Будгиагийн Дэлгэрхангай | -Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч |
| 2. Лхагважавын Бямбажав | -Архангай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын дарга | 7. Чунагийн Ендон | -Архангай аймгийн Эрдэнэбулган сумын барилгын үйлдвэрлэлийн "Цагаан сүмбэр" ХХК-ийн барилгачин |
| 3. Доржжүүгийн Давасүмбэрэл | -Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга | 8. Цэрэндоржийн Жавзан | -Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийн бага ангийн багш |
| 4. Цэдээгийн Дорждагва | -Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх байгаль орчны албаны дарга | 9. Дэндэрлэрэнгийн Жалбаажамц | -Архангай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал |
| 5. Цэрэнпунцагийн Дорждэрэм | -Архангай аймгийн Хотонт сумын Холбооны салбарын эрхлэгч | | |



- | | | | |
|-------------------------------|---|----------------------------------|---|
| 10. Хайдавын
Лхагваа | -Архангай аймгийн
Нийгмийн даатгалын
хэлтсийн дарга | 15. Лонжидын
Пунцагдаш | -Архангай аймгийн
Холбооны газрын дарга |
| 11. Намдагийн
Лхагважав | -Архангай аймгийн Ихтамир
сум дахь Өндөр уулын
бүсийн мал аж ахуйн эрдэм
шинжилгээний салбар
хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан | 16. Пунцагийн
Товууч | -Архангай аймгийн
Төвшрүүлэх сумын Засаг
даргын Тамгын газрын
ажилтан |
| 12. Арьхадын
Лхагвасүрэн | -Архангай аймгийн Хашаат
сумын Засаг даргын Тамгын
газрын дарга | 17. Батцэрэнгийн
Цэвээннамжил | -Архангай аймгийн Засаг
даргын Тамгын газрын
татварын хэлтсийн улсын
байцаагч |
| 13. Сандагийн
Лхамжав | -Архангай аймгийн Засаг
даргын дэргэдэх Боловсрол,
соёлын газрын дарга | 18. Нацагийн
Цэрэндорж | -Архангай аймгийн Цэнхэр
сумын малчин |
| 14. Лундаагийн
Махгалсүрэн | -Архангай аймгийн Чулуут
сумын Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн дарга | 19. Самдангийн
Шархүү | -Архангай аймгийн Ихтамир
сум дахь Өндөр уулын
бүсийн мал аж ахуйн эрдэм
шинжилгээний салбар
хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ахлах ажилтан |

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

- | | |
|----------------------------|---|
| Цэрэнпилийн
Цэрэнцэгмид | -Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хэсгийн
төлөөлөгч, цагдаагийн дэд хурандаа |
|----------------------------|---|

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | | | |
|---------------------------------|---|------------------------------------|--|
| 1. Дашдондогийн
Баавгай | -Архангай аймгийн Нэгдсэн
эмнэлгийн халдвартын
тасгийн эрхлэгч, их эмч | 11. Дэндэвийн
Дорждулам | -Архангай аймгийн
Эрдэнэмандал сумын Засаг
дарга |
| 2. Гэлэгдовдонгийн
Баасанжав | -Архангай аймгийн
Батцэнгэл сумын малчин | 12. Цэдэндамбын
Дэнсмаа | -Архангай аймгийн
Эрдэнэмандал сум дахь
сум дундын эмнэлгийн
хүүхдийн эмч |
| 3. Дамдэнсүрэнгийн
Бадам | -Архангай аймгийн Хашаат
сумын соёлын төвийн
эрхлэгч | 13. Цагааны
Жанлав | -Архангай аймгийн
Эрдэнэбулган сумын "Илч-
Архангай" ХК-ийн слесарьч |
| 4. Нанзадын
Батсүх | -Архангай аймгийн Ихтамир
сумын дунд сургуулийн
бага ангийн балш | 14. Цэрэнпунцагийн
Жүгдэрнамжил | -Архангай аймгийн
Эрдэнэбулган сумын 4
дүгээр цэцэрлэгийн багш |
| 5. Сэр-Одын
Баттөмөр | -Архангай аймгийн Засаг
даргын дэргэдэх Боловсрол,
соёлын газрын арга зүйч | 15. Түвдэнсүрэнгийн
Лхамрагчаа | -Архангай аймгийн
Эрдэнэбулган сумын 2
дугаар цэцэрлэгийн эрхлэгч |
| 6. Жамцын
Батцэцэг | -Архангай аймгийн Хотонт
сумын хүн эмнэлгийн
эрхлэгч, их эмч | 16. Очирбатын
Нямдаваа | -Архангай аймгийн Шуудан
холбооны газрын жолооч |
| 7. Алтангэрэлийн
Бямбажав | -Архангай аймгийн Засаг
даргын Тамгын газрын
татварын хэлтсийн дарга | 17. Жанлавын
Оюунчимэг | -Архангай аймгийн
Батцэнгэл сумын Хүн
эмнэлгийн дүн бүртгэгч бага
эмч |
| 8. Цэдэндамбын
Гаравцогзол | -Архангай аймгийн Өлзийт
сумын Бодонт багийн Засаг
дарга | 18. Дорждагвын
Сайнхишиг | -Архангай аймгийн
Эрдэнэбулган сумын зам
засвар, арчлалтын "Авто
зам" ХК-ийн гагнуурчин |
| 9. Чимэдбалжирын
Даваажав | -Архангай аймгийн Эрүүл
мэндийн газрын эх барих
эмэгтэйчүүдийн ерөнхий
мэргэжилтэн, их эмч | 19. Чимэдийн
Сүхбаатар | -Архангай аймгийн
Нийгмийн даатгалын
хэлтсийн ахлах байцаагч |
| 10. Вандангийн
Дашжамц | -Архангай аймгийн
Жаргалант сумын Засаг
даргын Тамгын газрын
татварын улсын байцаагч | 20. Чойсүрэнгийн
Таванжин | -Архангай аймгийн Хотонт
сумын дунд сургуулийн |



21. Дашнамжилын Тунгалаг	бага ангийн багш -Архангай аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга	26. Уртнэсангийн Чадраабал	-Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Илч- Архангай" ХК-ийн халаалтын зуухны слесарьч
22. Гүндсамбуугийн Цагаанлунх	-Архангай аймгийн Өндөр- Улаан сумын Азарга багийн Засаг дарга	27. Намхайн Шарав	-Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
23. Долгорсүрэнгийн Цогзолмаа	-Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн хагалгааны туслах	28. Рэнцэнгийн Энобиш	-Архангай аймгийн Хайрхан сумын дунд сургуулийн түүх, нийгмийн багш
24. Дашчирэвийн Цэдэнпилмаа	-УБИС-ийн харьяа Архангай аймаг дахь Багшийн коллежийн монгол хэл, уран зохиолын багш	29. Халхын Эрхэмбаяр	-Архангай аймгийн Хөгжимт драмын театрын уран сайхны удирдагч, хөгжмийн багш
25. Чимэдцэрэнгийн Цэрэндолгор	-Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн төлөөлөгч	30. Даваадэндэвийн Янжмаа	-Архангай аймгийн Хангай сумын дунд сургуулийн захирал

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дэчиндоржийн Батзориг	-Архангай аймгийн Цагдаагийн хэлтсийн ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч	цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
2. Төмөрийн Нямсүрэн	Архангай аймгийн Цагдаагийн хэлтсийн	

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

Адъяагийн Рэнчинд Монгол Улсын
хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр
бүтээлтэй хөдөлмөрлөж мал сүргээ өсгөн үржүүлэх,
ашиг шимийг бүрэн ашиглах, иргэдийг малжуулах,
мал маллагааны арга туршлагаа залуу малчдад
өвлүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг
нь үнэлж Завхан аймгийн Цэцэн-Уул сумын 3 дугаар

багийн малчин Адъяагийн Рэнчинд Монгол Улсын
хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын
одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасуугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

Лувсангэндэнгийн Аюушт Монгол
Улсын гавьяат багш цол хүртээх
тухай

Ерөнхий боловсролын сургуульд хими,
биологийн багшаар олон жил үр бүтээлтэй ажиллаж
заах аргын ур чадвар, сургалтын чанарыг
дээшлүүлэн, сурагчдад гүн бат мэдлэг олгох, өсвөр
үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа
хувь нэмрийг нь үнэлж Завхан аймгийн Улиастай
сумын Б.Элдэв-Очирын нэрэмжит "Чандмань-

Эрдэнэ" цогцолбор сургуулийн хими, биологийн багш
Лувсангэндэнгийн Аюушт Монгол Улсын гавьяат
багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Лавагийн Юрад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамж, удирдсан аж ахуйн нэгжийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Завхан зймгийн

"Завхан баялаг" ХК-ийн захирал Лавагийн Юрад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1997 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан "Уралдаант шалгаруулалтаар хувьчлах төрийн өмчийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн жагсаалт"-ын "Сүхбаатар дүүргийн ээлжийн сургуулийн дуусаагүй барилга" гэсэн 3 дахь заалтыг хассугай.

ээлжийн сургуулийн дуусаагүй барилгыг Соёл, урлагийн их сургуульд балансаас балансад шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Н.ЭНХБАЯР
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**
А.ЦАНЖИД

2. Сүхбаатар дүүргийн 0.42 га талбай бүхий

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"НИК" хувьцаат компанийн өр төлбөрийг шийдвэрлэх, нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан 2 дугаар хавсралтад, "Монгол даатгал" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувийг хувьчлах тухай" Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор батлагдсан 2 дугаар

хавсралтад, "Товь" хувьцаат компанийн хувьцааг худалдах тухай" 2003 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан 2 дугаар хавсралтад энэхүү тогтоолын хавсралтад дурдсан хэсгийг 13 дахь заалт болгон тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Н.ЭНХБАЯР
**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД**
Ч.УЛААН

Засгийн газрын 2003 оны 135 дугаар тогтоолын хавсралт

13. Гарын үсэг зурж байгуулсан Худалдах, худалдан авах гэрээг цуцалсан тохиолдолд Төрийн өмчийн хорооноос авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

13.1. Энэхүү Тендерийн журмын дагуу байгуулж, гарын үсэг зурж, хүргүүлсэн Худалдах, худалдан авах гэрээг худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгохгүйгээр аливаа шалтгаанаар цуцлах тохиолдолд Төрийн өмчийн

хороо нь доорхи арга хэмжээний аль нэгийг авч болно:

1) Худалдан авах удаах үнийг санал болгосон Тендэрт оролцогч этгээдэд (цаашид "Удаах байранд шалгарсан тендэрт оролцогч" гэх)

уг этгээдээс Тендерийн саналын хамт ирүүлсэн Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт гарын үсэг зурж, хэрэгжүүлэх саналыг бичгээр тавих;

2) Тендерийг дуусгавар болгох.

13.2. Энэхүү Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг удаах байранд шалгарсан тендерийн оролцогч нь хүлээн авахаас татгалзах буюу хүлээн авах тухайгаа Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд бичгээр мэдэгдэнэ. Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос санал тавихаар шийдвэрлэсэн боловч тендерт ялагчийн санал болгосон үнийн удаах үнийг техникийн саналын үнэлгээгээр адил оноо авсан нэгээс дээш оролцогч санал болгосон тохиолдолд Төрийн өмчийн хороо удаах байрны тендерийн оролцогчийг Тендерийн журмын 11.10-р зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулна.

13.3.1 Энэхүү Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд хүлээж авсан тохиолдолд удаах байранд шалгарсан Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараахь бичиг баримтыг гаргаж өгнө:

1) Энэхүү журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг хүлээн авахыг зөвшөөрч тухайн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас (консорциум болон оролцож буй тохиолдолд тухайн консорциумын гишүүн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас) гаргасан хүчин төгөлдөр шийдвэр;

2) Итгэмжлэгдсэн төлөөлөгч удаах байранд шалгарсан тендерт оролцогчийг төлөөлөх, уг журмын 13.1 (1)-р зүйлд дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэйг нотолсон хүчин төгөлдөр итгэмжлэл;

3) Тендерийн дэнчин төлснийг нотлох нотолгоо (удаах байранд шалгарсан Тендерийн оролцогчийн тендерийн дэнчинг буцааж

өгөөгүй байсан бол дэнчинг төлсөн нотолгоог шаардахгүй).

13.4. Удаах байранд шалгарсан Тендерийн оролцогч нь энэхүү журмын 13.3-р зүйлд дурдсан шаардлагыг хангасан тохиолдолд уг оролцогчоос тендерийн саналтайгаа хамт ирүүлсэн, худалдан авах удаах үнийг зааж бичсэн, Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн хувилбарт Төрийн өмчийн хорооны дарга гарын үсэг зурж, хуудас бүрийг нь үсэглэн итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь хүргүүлнэ. Талуудын харилцан тохиролцооноор Худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эцсийн хувилбарт зайлшгүй өөрчлөлт (энэ нь нөхцөл байдал өөрчлөгдсөнийг зохицуулахад зайлшгүй шаардагдаж болох өөрчлөлтөөр л хязгаарлагдах ба удаах байранд шалгарсан Тендерийн оролцогчийн санхүүгийн саналд тусгагдсан Худалдан авах үнийн дүнг өөрчлөхгүй) оруулах бол энэхүү өөрчлөлтийг Худалдах худалдан авах тухай гэрээнд оруулж, гэрээний хоёр тал тусгайлан үзэглэнэ.

13.5. Дараахь тохиолдолд тендерийг дуусгавар болгох буюу удаах байранд шалгарсан тендерт оролцогчийн дараачийн этгээдэд Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу дахин санал тавих шийдвэрийн аль нэгийг Төрийн өмчийн хороо өөрийн үзэмжээр бие даан гаргаж болно:

а) Удаах байранд шалгарсан тендерийн оролцогч нь энэхүү Тендерийн журмын 13.1 (1)-р зүйлийн дагуу Төрийн өмчийн хорооноос тавьсан саналыг хүлээн авахаас татгалзсан, эсвэл Төрийн өмчийн хорооноос тогтоосон хугацаанд саналыг хүлээн авснаа мэдэгдээгүй,

б) энэхүү Тендерийн журмын 13.3-р зүйлийн дагуу шаардсан бичиг баримтыг гаргаж өгөөгүй,

в) Гэрээний талууд аливаа бусад шалтгаанаар Худалдах, худалдан авах гэрээг байгуулж, уг гэрээний нөхцөл болзлын дагуу худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгож чадаагүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай

"Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай" Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хангуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

1. Хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд батлагдсан бүсийн тулгуур төв Ховд, Улиастай, Хархорин, Эрдэнэт, Зуунмод, Дархан, Чойбалсан, Өндөрхаан хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2003-2004 онд боловсруулж батлахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

3. Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах 565.0 (таван зуун жаран таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсугэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Н.ЭНХБАЯР
**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД**
Ч.УЛААН
**ДЭД БҮТЦИЙН
САЙД**
Б.ЖИГЖИД

2. Бүсийн тулгуур төв хотуудын хөгжлийг дэмжих талаар яамдаас баримтлах бодлоготой уялдуулан ерөнхий төлөвлөгөө боловсруулах техникийн даалгаврыг хамтран баталж биелэлтийг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

45	Дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохицуулах үндэсний хороо	Дэд бүтцийн сайд
----	--	------------------

"Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтад дор дурдсан агуулгатай 45 дахь заалт нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Н.ЭНХБАЯР
**ДЭД БҮТЦИЙН
САЙД**
Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, "Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

суралцаж байсан нэг хүүхдийн сургалтын төлбөрийг тухайн хүүхдийг уг сургуулиа төгсөх хүртэлх хугацаанд төрийн сургалтын сангаас санхүүжүүлж байх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

1. Байгууллага нь татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо хасагдсаны улмаас бүтцийн өөрчлөлтөд хамрагдаж төрийн албанаас чөлөөлөгдсөн нь тухайн төсөвт байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр нотлогдож байгаа төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд, мэргэжлийн сургуульд 2003 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар

2. Бүтцийн өөрчлөлтийн улмаас төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэний 2003 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар их, дээд, мэргэжлийн сургуульд суралцаж байсан хүүхдийн тоог холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэр, шаардлагатай бусад баримт бичигт тулгуурлан нарийвчлан тогтоож баталгаажуулсны үндсэн дээр санхүүжилтийг төрийн сургалтын сангаас олгож байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд



А.Цанжидад даалгасугай.

нарт даалгаж, Төрийн албаны зөвлөл (Ж.НОРОВСАМБУУ)-д зөвлөсүгэй.

3. Төрийн албаны бүтцийн өөрчлөлтөд хамрагдаж төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэнтэй хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохих тэтгэлэг, тэтгэмж олгох; одоо сурч байгаа нэг хүүхдийнх нь сургалтын зардлыг сургуулиа төгсөх хүртэлх хугацаанд төр хариуцах болон эдгээр арга хэмжээнд хамрагдсан тохиолдолд эргэж төрийн албанд орохгүй байх талаар гэрээ байгуулж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч (ерөнхий менежер, тэдгээртэй адилтгах албан тушаалтнууд)

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД** **Ч.УЛААН**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Соёлын тухай хуулийн 21.9-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт багтаан санхүүжүүлж байсугай.

1. Ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журмыг хэвсрэлт өсөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

2. Ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авахад шаардагдах хөрөнгийг

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2003 оны 140 дүгээр тогтоолын хэвсрэлт

НОМ, ХЭВЛЭЛИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САНД ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

судлаач, шүүмжлэгч, эрдэмтдийн төлөөллөөс бүрдсэн өсөөс доошгүй гишүүнтэй байна.

1.1. Шинээр хэвлэгдэн гарч байгаа ном, хэвлэлийн шилдэг бүтээлээс улсын санд шалгаруулан худалдан авах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна.

1.2. Худалдан авсан ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг Улсын төв номын сан болон аймаг, нийслэлийн төв номын санд хадгална.

2.4. Зөвлөлийн хуралдааныг жилд нэг удаа хуралдуулна.

1.3. Ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг жилд нэг удаа шалгаруулан худалдан авна.

2.5. Зөвлөлийн нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар санал, дүгнэлт гаргана.

Хоёр. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

2.1. Ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг шинжлэн үзэж, үнэлгээ өгөх, улсын санд худалдан авах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг (цаашид "зөвлөл" гэх) соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилон ажиллуулна.

2.6. Зөвлөлийн гишүүн өөрийн бүтээлээ худалдаж байгаа буюу өмнөх үг, шүүмж бичсэн, редакторласан бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй.

2.2. Зөвлөл нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийтийн номын сан, хэвлэлийн үйлдвэр болон зохиолч, утга зохиол

2.7. Зөвлөлийн санал, дүгнэлтийг хуралдаанд оролцсон Зөвлөлийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.8. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвлөлөөс гаргасан санал,



дүгнэлтийг үндэслэн шалгарсан ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах шийдвэр гаргана.

2.9. Улсын санд худалдан авах номын нэр төрөл, тоо хэмжээ, байршуулах газрыг Зөвлөл тодорхойлно.

Гурав. Шилдэг ном, хэвлэлийг шалгаруулах, худалдан авах

3.1. Шалгаруулалтад тухайн онд хэвлэгдсэн шинэ бүтээл орох бөгөөд бүтээлийг шалгаруулалт болохоос нэг сарын өмнө Зөвлөлд ирүүлнэ.

3.2. Шалгаруулалтад орох бүтээл дараахь шаардлагыг хангасан байна:

-нийт уншигчдад зориулсан лавлагаа-танин мэдэхүйн зохиол, урлаг, уран зохиол, түүхийн болон эрдэм шинжилгээний хялбаршуулсан бүтээлийн аль нэг төрөлд хамрагдаж байх;

-хэвлэлийн бүтээгдэхүүнд тавигдах олон

улсын стандартыг хангасан байх.

3.3. Ном, хэвлэлийн шилдэг бүтээлд тухайн онд хэвлэгдэн гарсан уран зохиол, шинжлэх ухаан, танин мэдэхүй, түүхийн онцгой ач холбогдолтой ном, хэвлэл хамаарна.

3.4. Улсын сангийн бүртгэл хөтлөх, шилдэг ном, хэвлэлийг хуваарийн дагуу түгээх, худалдан авсан бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хангах, сэргээн засварлах ажлыг Улсын төв номын сан хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгарсан бүтээлийг санхүүжүүлэх, хөрөнгийг зарцуулах

4.1. Шалгарсан ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авахад шаардагдах хөрөнгийг Соёл, урлагийн сангаас санхүүжүүлнэ.

4.2. Ном, хэвлэлийн шилдэг бүтээл авах зардлыг улсын төсвөөс олгосон хэмжээнд багтаан санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатны /2003-2007 оны/ төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулан явцад нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт үүрэг болгосугай.

3. Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив,

тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрүүдийн тухай" Засгийн газрын 1996 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

У.БАРСБОЛД

Засгийн газрын 2003 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Цөлжилтийн өнөөгийн байдал

Монгол орон газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, газар нутгийн гадаргын хэв шинж, экологийн тогтолцооны хувьд нэн эмзэг,

хуурай бүс нутагт хамрагддагийн улмаас түүхэн хөгжлийнхөө турш ган, цөлжилтөд нэрвэгдсээр ирсэн билээ.

Далай тэнгисээс алслагдсан эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадас багатай, далайн түвшнээс дунджаар 1580 м дээш өргөгдсөн монгол

орны нутаг дэвсгэрийн 42,5 хувийг эзлэх говь, цөлийн бүсэд үржил шим муутай, цөлөрхөг, хээрийн болон говийн бор хөрс зонхилж, тачир сийрэг ургамлын нөмрөгөөр бүрхэгдсэн байна.

Судалгаанаас үзэхэд дэлхий дахины дулааралт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур 1,56 хэмээр нэмэгдэж, нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг хамарсан ган 2-3 жилийн, нутгийн 50 хувиас илүү хэсгийг хамарсан ган 4-5 жилийн давтамжтай тохиолдож байгаа бөгөөд 1960 онтой харьцуулахад тал хээр, говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 3-4 дахин өссөн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилтийн үйл явц эрчимжиж байгаа нь мөнх цас хайлах, нуур гол, горхи ширгэх, бэлчээрийн ургамлын гарц эрс муудах, хөрс, ус давсжих, элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх, байгалийн элдэв гамшгийн давтамж нэмэгдэх зэргээр илэрч байна. Байгалийн хүчин зүйлээс гадна хүний олон талт үйл ажиллагаа цөлжилтийг хурдасгахад ихээхэн нөлөөлж байна. 1990 оноос малын тоо толгой нэмэгдэхийн зэрэгцээ бэлчээрийн усан хангамж муудсан, хөрсний талхидал ихэссэн нь бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглахад хүргэж улмаар газар нутаг цөлжих нэг шалтгаан болсон. Монгол орны 126,6 сая га талбай бүхий бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр талхидалд орсноор бэлчээрийн ургамлын ургац хэд дахин буурч мал сүргийн нэлээд хэсэг тэжээлээр хомсдож тоо толгой цөөрөх, ашиг шим буурахад нөлөөлж байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн 8 орчим хувийг эзэлдэг ойн талбайн 40 хувь нь хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас нөөц нь жилээс жилд хомсдон хортон шавьж, түймэрт нэрвэгдсээр байна. Цөлийн бүсийн элсний үндсэн ургамал болох заган ойг их хэмжээгээр ашигласнаас 125,0 мянган га газрын заг бүрэн устжээ. Гандуу бүс нутгийн аймаг, сумын төв зэрэг төвлөрөл ихтэй нутгийн хүн ам орчныхоо модлог ургамал, бут сөөг, шаваг, харгана зэргийг түлшинд хэрэглэх явдал үргэлжилсээр байна.

Монгол орны газар зүй, уур амьсгалын байдлаас шалтгаалан нийт нутгийн 90 гаруй хувь нь хуурай, хагас хуурай, хуурайвтар, чийг дутмаг нутагт хамрагддаг бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 41,3 хувь буюу 647,0 мянган ам.километр талбай бүхий говь, цөлийн бүс нутаг цөлжих аюулд илүү өртөгдөж хэмжээ нь тэлсээр байна.

Гандуу нутгийн цөлжилтийн үйл явцын хандлагыг дараахь хүснэгтэд хувиар үзүүлээ:

Цөлжилтийн зэрэглэл, хамрах нутгийн хүрээ	1990 онд	2000 онд
Цөлжилт сул илэрсэн нутаг	76,0	34,9
Цөлжилт дунд зэрэг илэрсэн нутаг	20,0	38,7
Цөлжилт хүчтэй илэрсэн нутаг	3,0	16,1
Цөлжилт маш хүчтэй илэрсэн нутаг	1,0	1,8
Хэт гандуу цөл нутаг	-	8,5
Гандуу нутгийн эзлэх талбай	41,3	44,7

Дээрх хүснэгтээс үзэхэд 1990-2000 он хүртэлх 10 жилийн хугацаанд гандуу нутгийн эзлэх талбай 3,4 хувиар ихэсч цөлжилт хүчтэй илэрсэн нутгийн талбай 5,4 дахин, маш хүчтэй илэрсэн нутгийн талбай 1,8 дахин нэмэгдсэн байна.

2000 оны байдлаар монгол орны нутаг дэвсгэрийн 33,8 хувийг эзлэх хээрийн бүсийн бэлчээрийн экосистем хүний үйл ажиллагааны улмаас ихээхэн доройтсоны дотор зэрэглэлээр авч үзвэл 11,6 хувь нь их, 2,0 хувь нь маш их доройтолд багтах болжээ.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, бодит шаардлага

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах болсон шаардлага, бодит үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлж байна:

2.1. нийт хүн амын 40 гаруй хувь нь байгалиас үлэмж хамааралтай мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг Монгол орны хувьд цөлжилттэй тэмцэх, түүнд дасан зохицох асуудлыг төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэн багагүй арга хэмжээ авч байгаа боловч дорвитой үр дүнд хүрэхгүй байна;

2.2. дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улс орны эдийн засаг, нийгмийн амьдрал, хүмүүсийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл мэдэгдэхүйц нэмэгдэж, цөлжилтийн үйл явц асар их эрч хүчтэй болж байгаа өнөө үед түүнийг сөрөн тэмцэх, дасан зохицох бодлогыг шинээр томъёолох зайлшгүй шаардлага тулгарч байна;

2.3. даяаршлын эрин үед аливаа улс зөвхөн өөрийн хүч боломжид тулгуурлан тогтвортой хөгжилд хүрэх боломж, нөхцөл улам бүр хумигдаж, гадаад улс орон, олон нийтийн хамтын хүчин чармайлтыг нэгтгэн зохион байгуулж, байгаль, цаг агаарын онц аюултай үзэгдлийн эсрэг хамтран тэмцэх, харилцан уялдаатай, цэгцтэй бодлого



дүгнэлтийг үндэслэн шалгарсан ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах шийдвэр гаргана.

2.9. Улсын санд худалдан авах номын нэр төрөл, тоо хэмжээ, байршуулах газрыг Зөвлөл тодорхойлно.

Гурав. Шилдэг ном, хэвлэлийг шалгаруулах, худалдан авах

3.1. Шалгаруулалтад тухайн онд хэвлэгдсэн шинэ бүтээл орох бөгөөд бүтээлийг шалгаруулалт болохоос нэг сарын өмнө Зөвлөлд ирүүлнэ.

3.2. Шалгаруулалтад орох бүтээл дараахь шаардлагыг хангасан байна:

-нийт уншигчдад зориулсан лавлагаа-танин мэдэхүйн зохиол, урлаг, уран зохиол, түүхийн болон эрдэм шинжилгээний хялбаршуулсан бүтээлийн аль нэг төрөлд хамрагдаж байх;

-хэвлэлийн бүтээгдэхүүнд тавигдах олон

улсын стандартыг хангасан байх.

3.3. Ном, хэвлэлийн шилдэг бүтээлд тухайн онд хэвлэгдэн гарсан уран зохиол, шинжлэх ухаан, танин мэдэхүй, түүхийн онцгой ач холбогдолтой ном, хэвлэл хамаарна.

3.4. Улсын сангийн бүртгэл хөтлөх, шилдэг ном, хэвлэлийг хуваарийн дагуу түгээх, худалдан авсан бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хангах, сэргээн засварлах ажлыг Улсын төв номын сан хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгарсан бүтээлийг санхүүжүүлэх, хөрөнгийг зарцуулах

4.1. Шалгарсан ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авахад шаардагдах хөрөнгийг Соёл, урлагийн сангаас санхүүжүүлнэ.

4.2. Ном, хэвлэлийн шилдэг бүтээл авах зардлыг улсын төсвөөс олгосон хэмжээнд багтаан санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатны /2003-2007 оны/ төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулан явцад нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт үүрэг болгосугай.

3. Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив,

тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улванд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрүүдийн тухай" Засгийн газрын 1996 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

У.БАРСБОЛД

Засгийн газрын 2003 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Цөлжилтийн өнөөгийн байдал

Монгол орон газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, газар нутгийн гадаргын хэв шинж, экологийн тогтолцооны хувьд нэн эмээг,

хуурай бүс нутагт хамрагддагийн улмаас түүхэн хөгжлийнхөө турш ган, цөлжилтэд нэрвэгдсээр ирсэн билээ.

Далай тэнгисээс алслагдсан эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадас багатай, далайн түвшнээс дунджаар 1580 м дээш өргөгдсөн монгол

орны нутаг дэвсгэрийн 42,5 хувийг эзлэх говь, цөлийн бүсэд үржил шим муутай, цөлөрхөг, хээрийн болон говийн бор хөрс зонхилж, тачир сийрэг ургамлын нөмрөгөөр бүрхэгдсэн байна.

Судалгаанаас үзэхэд дэлхий дахины дулааралт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур 1,56 хэмээр нэмэгдэж, нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг хамарсан ган 2-3 жилийн, нутгийн 50 хувиас илүү хэсгийг хамарсан ган 4-5 жилийн давтамжтай тохиолдож байгаа бөгөөд 1960 онтой харьцуулахад тал хээр, говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 3-4 дахин өссөн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилтийн үйл явц эрчимжиж байгаа нь мөнх цас хайлах, нуур гол, горхи ширгэх, бэлчээрийн ургамлын гарц эрс муудах, хөрс, ус давсжих, элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх, байгалийн элдэв гамшгийн давтамж нэмэгдэх зэргээр илэрч байна. Байгалийн хүчин зүйлээс гадна хүний олон талт үйл ажиллагаа цөлжилтийг хурдасгахад ихээхэн нөлөөлж байна. 1990 оноос малын тоо толгой нэмэгдэхийн зэрэгцээ бэлчээрийн усан хангамж муудсан, хөрсний талхигдал ихэссэн нь бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглахад хүргэж улмаар газар нутаг цөлжих нэг шалтгаан болсон. Монгол орны 126,6 сая га талбай бүхий бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр талхигдалд орсноор бэлчээрийн ургамлын ургац хэд дахин буурч мал сүргийн нэлээд хэсэг тэжээлээр хомсдож тоо толгой цөөрөх, ашиг шим буурахад нөлөөлж байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн 8 орчим хувийг эзэлдэг ойн талбайн 40 хувь нь хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас нөөц нь жилээс жилд хомсдон хортон шавьж, түймэрт нэрвэгдсээр байна. Цөлийн бүсийн элсний үндсэн ургамал болох заган ойг их хэмжээгээр ашигласнаас 125,0 мянган га газрын заг бүрэн устжээ. Гандуу бус нутгийн аймаг, сумын төв зэрэг төвлөрөл ихтэй нутгийн хүн ам орчныхоо модлог ургамал, бут сөөг, шавяг, харгана зэргийг түлшинд хэрэглэх явдал үргэлжилсээр байна.

Монгол орны газар зүй, уур амьсгалын байдлаас шалтгаалан нийт нутгийн 90 гаруй хувь нь хуурай, хагас хуурай, хуурайвтэр, чийг дутмаг нутагт хамрагддаг бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 41,3 хувь буюу 647,0 мянган ам.километр талбай бүхий говь, цөлийн бүс нутаг цөлжих аюулд илүү өртөгдөж хэмжээ нь тэлсээр байна.

Гандуу нутгийн цөлжилтийн үйл явцын хандлагыг дараахь хүснэгтэд хувиар үзүүлэв:

Цөлжилтийн зэрэглэл, хамрах нутгийн хүрээ	1990 онд	2000 онд
Цөлжилт сул илэрсэн нутаг	76,0	34,9
Цөлжилт дунд зэрэг илэрсэн нутаг	20,0	38,7
Цөлжилт хүчтэй илэрсэн нутаг	3,0	16,1
Цөлжилт маш хүчтэй илэрсэн нутаг	1,0	1,8
Хэт гандуу цөл нутаг	-	8,5
Гандуу нутгийн эзлэх талбай	41,3	44,7

Дээрх хүснэгтээс үзэхэд 1990-2000 он хүртэлх 10 жилийн хугацаанд гандуу нутгийн эзлэх талбай 3,4 хувиар ихэсч цөлжилт хүчтэй илэрсэн нутгийн талбай 5,4 дахин, маш хүчтэй илэрсэн нутгийн талбай 1,8 дахин нэмэгдсэн байна.

2000 оны байдлаар монгол орны нутаг дэвсгэрийн 33,8 хувийг эзлэх хээрийн бүсийн бэлчээрийн экосистем хүний үйл ажиллагааны улмаас ихээхэн доройтсоны дотор зэрэглэлээр авч үзвэл 11,6 хувь нь их, 2,0 хувь нь маш их доройтолд багтах болжээ.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, бодит шаардлага

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах болсон шаардлага, бодит үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлж байна:

2.1. нийт хүн амын 40 гаруй хувь нь байгалиас үлэмж хамааралтай мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг Монгол орны хувьд цөлжилттэй тэмцэх, түүнд дасан зохицох асуудлыг төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэн багагүй арга хэмжээ авч байгаа боловч дорвитой үр дүнд хүрэхгүй байна;

2.2. дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улс орны эдийн засаг, нийгмийн амьдрал, хүмүүсийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл мэдэгдэхүйц нэмэгдэж, цөлжилтийн үйл явц асар их эрч хүчтэй болж байгаа өнөө үед түүнийг сөрөн тэмцэх, дасан зохицох бодлогыг шинээр томьёолох зайлшгүй шаардлага тулгарч байна;

2.3. даяаршлын эрин үед аливаа улс зөвхөн өөрийн хүч боломжид тулгуурлан тогтвортой хөгжилд хүрэх боломж, нөхцөл улам бүр хумигдаж, гадаад улс орон, олон нийтийн хамтын хүчин чармайлтыг нэгтгэн зохион байгуулж, байгаль, цаг агаарын онц аюултай үзэгдлийн эсрэг хамтран тэмцэх, хэрилцэн уялдаатай, цэгцтэй бодлого

боловсруулж хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна.

2.4. Монгол Улс 1996 онд нэгдэн орсон "Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенци"-ийг хэрэгжүүлэх хүрээнд эх орныхоо цөлжилтийн өнөөгийн үйл явцад бодитой дүгнэлт хийж, үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулах, цөлжилттэй тэмцэх бодлого чиглэлээ тодорхойлох шаардлагатай болоод байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

3.1. Хөтөлбөрийн зорилго

Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж улам эрчимжиж байгаа цөлжилтийн сөрөг нөлөөллийг багасгах, түүнд дасан зохицох арга замыг тодорхойлох, байгаль орчноо тэтгэх хүрээнд нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр цөлжилтийн үйл явцыг сааруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Хөтөлбөрийн үндсэн зорилт

Хөтөлбөрийн үндсэн зорилтыг дор дурдсанаар тодорхойлж байна:

3.2.1. Цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчин, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг боловсронгуй болгох, цөлжилтийн үйл явцад дасан зохицох, цөлжилтөд нэрвэгдэж байгаа газар нутгийн бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3.2.2. Цөлжилтийн шалтгаан, түүний тархалт, цөлжилтийн улмаас монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны ажлын цар хүрээ, онол арга зүйн түвшин, практик үр өгөөжийг нэмэгдүүлэх;

3.2.3. Цөлжилттэй тэмцэх үндэсний технологи нэвтрүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээх арга хэмжээг өргөжүүлэх;

3.2.4. Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, олон улсын хамтын ажиллагаа, олон нийтэд хүргэх мэдээлэл, сурталчилгаа, сургалтын хүрээг өргөтгөх.

3.3. Хэрэгжүүлэх үе шат

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг үе шатаар хэрэгжүүлнэ:

I ҮЕ ШАТ /2003-2007 он/-нд цөлжилтийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч цөлжилтийг бууруулах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг сайжруулж цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх, түүнд дасан зохицох бэлтгэлийг хангахад чиглэгдсэн цогц асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх;

II ҮЕ ШАТ /2008-2011 он/-нд цөлжилтийн үйл явцад хяналт шинжилгээ хийх, дасан зохицох чадавхийг бэхжүүлж, цөлжилтөд хүчтэй өртөж байгаа эмзэг бүс нутгийн доройтсон орчинг нөхөн сэргээх замаар цөлжилтийн эрч хүчийг сааруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

Ш ҮЕ ШАТ /2012 оноос/-нд цөлжилтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга механизмыг бүрэн ашиглаж, цөлжилтөд дасан зохицох бодлогын үр шимийг хүртэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрт хөтөлбөрийн зорилго, ач холбогдол, хүрэх үр дүн, байгууллага, хүн бүрийн оролцоог олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарлан сурталчлах, сургалт зохион байгуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь тэргүүн зэргийн асуудал байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1. хөтөлбөр нь эрх зүй, нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны шинэ тогтолцооны нөхцөлд байгальтай уялдан зохицож, экосистемийг дэмжин тэтгэх замаар экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд ашигтай байх, төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, бодлогын залгамж халааг баримтлах;

4.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн хувь нэмрийг хөхиүлэн дэмжих, хууль тогтоомжийг чанд сахин биелүүлдэг дадал заншилд сургаж хэвшүүлэх;

4.3. Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу газрыг эзэнтэй болгож, эзэмшигч нь хариуцан хамгаалдаг, арчилж торддог, үр шимийг нь зүй зохистой

хэлбэрээр хүртдэг, нөхөн сэргээдэг механизмыг нэвтрүүлж хэвшүүлэх, эдийн засгийн хөшүүргүүдийг оновчтой ашиглах дадал заншил эзэмшүүлэх.

сааруулах дэвшилтэт технологи боловсруулалт нэвтрүүлж хэрэгжилтийг тухай бүр үнэлж байх;

5.3.3. говь, цөлийн бүсийн доройтсон экосистемийн байршил нутгийг улс, орон нутгийн хамгаалалтад авах;

5.3.4. гандуу бус нутгийн түлшний асуудлыг шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчийг эрчимтэй ашиглах;

5.3.5. цөлжсөн нутагт мод сөөг тарих, мод үржүүлгийн талбай байгуулах замаар ойжуулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх;

5.3.6. говь, хээрийн бүсийн бэлчээрийг усжуулах, усалтын систем, цас, борооны усыг тогтоох байгууламж барих;

5.3.7. уул уурхайн үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.3.8. үлийн цагаан оготно, хортон мэрэгчидтэй байгальд сөрөг нөлөөгүй, дэвшилт аргаар тэмцэх.

5.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

5.4.1. цөлжилттэй тэмцэх төв, орон нутгийн зохих байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;

5.4.2. цөлжилттэй тэмцэх талаар сургалт сурталчилгааг өргөжүүлэх;

5.4.3. цөлжилттэй тэмцэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгалийн нөөцийн менежментийг нэвтрүүлэх;

5.4.4. цөлжилтөд нэрвэгдсэн нутгийн хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх;

5.4.5. цөлжилттэй тэмцэх ажилд олон нийтийг татан оролцуулах эдийн засгийн урамшууллын оновчтой механизмыг судалж нэвтрүүлэх;

5.4.6. цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцийн гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх, цөлжилттэй тэмцэхэд гадаадын хөрөнгө санхүүгийн дэмжлэг, санаачилгыг дайчлан оролцуулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

5.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

5.1.1. цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

5.1.2. цөлжилттэй тэмцэх салбар дундын шинж чанартай бие даасан удирдлагын чадавхи, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох;

5.1.3. цөлжилттэй тэмцэх, сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.

5.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд:

5.2.1. цөлжилт, газрын доройтлын экологи-эдийн засгийн үнэлгээний нэгдсэн аргачлал боловсруулж, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд учрах сөрөг үр дагаврыг тогтоох;

5.2.2. ган, цөлжилтийн явц, орчны өөрчлөлтийг хянах хяналт шинжилгээний сүлжээ бүрдүүлж, түүнээс урьдчилан мэдээлэх арга хэмжээ авах;

5.2.3. газар зүйн мэдээллийн систем ашиглан цөлжилтийн мэдээллийн сан байгуулах;

5.2.4. бус нутгийн болон орон нутгийн хэмжээнд цөлжилтийн судалгааны ажлыг зохион байгуулж, түүнтэй тэмцэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах.

5.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд:

5.3.1. бэлчээрийн эдэлбэр газар, газар тариалангийн тогтвортой менежментийг бий болгох;

5.3.2. уламжлалт арга, орчин үеийн шинжлэх ухааны ололт, судалгаа шинжилгээний төсөл, арга хэмжээний үр дүнд тулгуурлан хөрс, ургамлын нөмрөгийг хамгаалах, элсний нүүлтийг



4	<p>Уур амьсгалын өөрчлөлт, ган цөлжилт, дасан зохицох үйл ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>6 Доройтсон орчныг нөхөн сэргээх, элсний нүүстгийг сэвэрлэх зорилгоор зарим доройтсон газар нутаг, хатаж ширхэж байгаа гол, нуурыг урсын тусгай хамгаалалтад авч, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх</p> <p>1 Мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан шинэстгэж аргаар холжүүлэх бодлого боловсруулахдаа мал аж ахуйг эрхэлж ирсэн уламжлалт арга, орчин үеийн технологийн дэвшилийг эвл, холцуулахад онцгой анхаарах</p> <p>2 Олон наст ургамал тармаглах тал хээр, өндөр уулын бүсэд нутгийн ургамлын цэвэрлэгт хүрээлэн байгуулж хадгалан бэлчээрийн талбейг нөхөн сэргээх, тэгээд үйлдвэрлэлийн системийг өөрчлөн сайжруулах</p> <p>3 Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагад нийцүүлэн таримал ургамлын тармалалтын технологийг томилох, тундэд орны өөрчлөлттэй үйлдүүлэн шинэчлэн тогтоож, чийг бага шавардаг, гөнд тэсвэртэй таримлын шинэ сортыг сууриалж хэрэглэх</p> <p>4 Бэлчээрийн даац, чадалд нь тохирсон менежментээр мал аж ахуйн үйлдвэрлэлийг эргэлэн хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх</p>	<p>2003-2007 он</p> <p>2003 оноос</p> <p>2003-2004 онд</p> <p>2004-2005 онд</p> <p>2003-2004 онд</p> <p>2003-2005 онд</p> <p>2003-2004 онд</p>	<p>Доройтсон орчныг нөхөн сэргээх, элсний нүүстгийг сэвэрлэхэд дэмжэх үүрэгтэй</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хувьсан өөрчлүүлж байгаа нохицолд нь зохицуулан эрсдэл багасгайгаар эргэлэн хөтлөх боломж нээгдэнэ</p> <p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эмзэг байдлыг бууруулах</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон газар тармалалтын үйлдвэрлэлийг хөгжүүлэх болтлоо болно</p> <p>Малын тоо толгойг бэлчээрийн даацад нь тохирүүлэн зохицуулах, бэлчээрийг зохицтой ашиглах, улмаар газрын элсхэрлэл, доройтлоог хамгаалах нөхцөл бүрдэнэ</p> <p>Цогцмилт эрчимтэй явагдаж байгаа бүс нутагт байгалийн нөөцийн зохицтой менежмент нэвтрүүлэх эхлэл тавигдана</p> <p>Ус, чийг дутмаг, залуун хүүрэй уур амьсгалтай манай орны хувьд усны нөөцийг зохицтой ашиглах, усны хангамжийн асуудлыг сайжруулахад дэмжэх болно</p>	<p>Байгаль орчны нам, нутгийн засиргааны байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд</p>
---	--	---	--	--	--

5	Цөлжилттэй тэмцэхэд олон нийтийн оролцоо, мэдээлэл сурталчилгааны цар хүрээг өргөтгөх	1.Цөлжилт, газрын доройтлын шалтгаан, үр дагавар, түүнээс сэргийлэх болон тэмцэх арга замын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах сургалт зохион байгуулах, мэдээ материалаар хангах 2.Байгалийн нөөц баялгийг зохиистой ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийн доройтлыг бууруулахад нутгийн иргэдийн оролцоог өргөтгөх, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ойн зурвас байгуулах, газрыг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээнд өргөнөөр оролцуулах, идэвхи санаачилгыг өрнүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн санаачилгыг дэмжих ажил зохион байгуулах	2003 оноос	Ард иргэдийн мэдлэг, мэдээлэл сайжирч, цөлжилтөөс сэргийлэх ухамсар төлөвшиж, экологийн боловсрол нь дээшилнэ	Байгаль орчны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, хэвлэл мэдээллийн байгууллагууд
		2003-2005 онд	Малчид хөдөлмөрөө хорших замаар байгалийн нөөцийг хамгаалан, зохиистой ашиглаж байгаа аймаг, сумдын туршлагыг нийтэд дэлгэрүүлнэ	Байгаль орчны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, нутгийн захиргааны байгууллагууд	
		2003 оноос	Орон нутгийн иргэдийн оролцоо сайжирч, цөлжилттэй тэмцэх ажилд бодитой үр дүн гарна	Холбогдох яамд, нутгийн захиргааны байгууллагууд	

<p>4.Целжилттэй үндэсний хэрэгжүүлэхэд дотоодын дэмжлэгийг зорилгоор талуудын уулзалт, семинар, ярилцлага зохион байгуулах</p>	<p>Монгол орны тэмцэхэд гадаад орнууд, олон улсын байгууллага, дотоодын дэмжлэгт түшиглэн хамтран ажиллах боломж бүрдэнэ</p>	<p>Байгаль орчны яам</p>
<p>5.Целжилттэй үйл ажиллагааг бууруулах, тогтвортой дэмжих арга хэмжээтэй нягт уялдуулан зохион байгуулах</p>	<p>Ядуу, нэн ядуу амьдралтай иргэдийг төсөл, арга хэмжээнд хамруулснаар ажлын байртай болж тэдгээрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж нээгдэнэ</p>	<p>Байгаль орчны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, нутгийн захиргааны байгууллагууд</p>

Ногол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Тайг. <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвөлөг.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Ушанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 326487

Хэвлэлийн хуудас 2.5